

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 11 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<p><b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон шинээр батлагдах Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиудын хүрээнд Улаанбаатар хотын салбаруудын бодлогын баримт бичгийг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, дараагийн Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах</p>				
1	<p>Дүүргийн Хууль, эрх зүйн хэлтсээс Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөлд 4 саналыг хүргүүлсэн.</li> </ul> <p>Барилга хот байгуулалтын яаманд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ “Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн төсөл”-д 2 санал</li> <li>➢ Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн “Сэлбэ голыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах талаарх газрын бүсэд холбогдох нийт 6 санал</li> <li>➢ Хаягжуулалтын тухай хуулийн төсөлд 2 санал</li> <li>➢ “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах 3 саналыг тус тус хүргүүлсэн.</li> </ul> <p>Нийслэл хотод тулгамдаж буй асуудлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах 2 нийт 19 саналыг боловсруулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэн ажилласан</p> <p>Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийн хүрээнд Засаг даргаас 2023 онд дээд шатны байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журмын төсөлд санал, үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр тайлагнаж хүргүүлсэн бөгөөд нийт 78 санал, арга хэмжээний хөтөлбөрийн 1 удаагийн биелэлтийг тус тус хүргүүлэн ажилласан.</p>			90
<p><b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагууд гадаад томилолтоор ажиллах тохиолдолд нийслэлийн Удирдлагуудад танилцуулах, цаашид гадаадад томилолтоор ажилласан тухай мэдээллийг Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж байх.</p>				

2	<p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1126 дугаар захирамжийг үндэслэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 2023 оны 10 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд БНСУ-ын Инчон хотын Ёнсу дүүрэгт,</li> <li>➢ 2023 оны А/1127 дугаар захирамжийг үндэслэн Япон улсын Шизүока мужийн Яйзү хотод 2023 оны 10 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд тус тус албан томилолтоор ажилласан тайланг цаг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Энэ сард гадаад албан томилолт байхгүй болно.</li> </ul>			90
<b>Үүрэг даалгавар ГУРАВ:</b> Нийслэлийн /дүүргийн / хэмжээнд өмчийн бүртгэл тооллогыг зохион байгуулах ажлыг хэсгийг байгуулах.				
3	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/336 тоот тушаалаар Эд хөрөнгийн бүтэн жилийн тооллого явуулах тухай тушаалын дагуу 2023 оны 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулан 50 ажиллаж байна. Тооллогын ажлын явц 50 хувьтай явагдаж байна.</p>			90
<b>Үүрэг даалгавар ДӨРӨВ:</b> “Цахилгаан халаагуур” тараах, бүртгэл судалгааг нарийвчлан гаргаж, бэлтгэл хангах ажлын хэсгийг байгуулж, “Цахилгаан халаагуур”-ын талаар олон нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг зохион байгуулах				
4	<p>Дүүргийн хэмжээнд цахилгаан халаагуур шаардлагатай айл өрхийн судалгааг гаргаж нэгтгэн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын мэргэжилтэн Э.Цогзолмаад ERP цахим хаягаар хүргүүлсэн.</p>			30
<b>Үүрэг даалгавар ТАВ:</b> Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох байгууллагууд санал өгч, 12 дугаар сардаа багтаан төслийг эцэслэх ажлыг зохион байгуулах.				
5	<p>Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах 6 саналыг Барилга, хот байгуулалтын яаманд 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 3/1625 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>			90
<b>Үүрэг даалгавар ЗУРГАА:</b> Нийслэлийн 2024 оны төсөв батлагдахад нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, 2024 оны 01 дүгээр сардаа зарлаж дуусгах, 02 дугаар сарын 01-ны дотор гэрээ байгуулах.				
6	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга, журам мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан тендерийн баримт бичийг боловсруулах бэлтгэл ажлыг ханган 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.</p> <p>Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь 2024 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг дүүргийн захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн өдрөөс ажлын гурван хоногт багтаан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим системээр дамжуулан ил тод нээлттэй урилга, үр дүнг нийтлэн шуурхай ажиллана.</p>			90

<b>Үүрэг даалгавар ДОЛОО:</b> УИХ-д өргөн барьсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль болон бусад хуулиуд батлагдахад хуулийг хэрэгжүүлэх журмуудыг НИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх.			
7	“Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөлд оруулах 4 саналыг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/181 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгийн газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.		90

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
НЭГТГЭСЭН:

Э.ХУЛАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ